




ДУЛААНЫ ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

*Эх орноо хөгжилд хөтлөх
эргийн хүчийг бүтээнэ*



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**БИДНИЙ
ЭРХЭМ ЗОРИЛГО**



*Эх орноо хөгжилд хүргэх
эрчим хүчийг бүтээнэ*

**БИДНИЙ
ХЭТИЙН ЗОРИЛГО**



*2021 онд хүний хөгжлийг
дээдэлсэн байгаль орчинд
ээлтэй дэлхийн жишигт
хүрсэн компани болох*

АГУУЛГА

1.	КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЦ	2-4
2.	КОМПАНИЙН НЭГЖ, ХЭСГИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ	5-8
3.	КОМПАНИЙН 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН БИЕЛЭЛТ.....	9
4.	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН	10-20
5.	КОМПАНИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, СУРГАЛТ ХӨГЖИЛ	21-22
6.	ӨВЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ, ИХ ЗАСВАРЫН ТАЛААР	23-24
7.	ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ	25-27
8.	ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТАЛААР	28
9.	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ	29-33
10.	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	33
11.	ISO 9001-2015 СТАНДАРТ, ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТ	34 -35
12.	АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ	35-36
13.	ИЛ ТОД ЁС ЗҮЙН БАЙДАЛ	37
14.	2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	37
15.	ДҮГНЭЛТ	38
16.	2021 ОНЫ ЗОРИЛТ	39

1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


“ДЦС-3” ТӨХК-ийн дунд даралтын хэсгийн суурийг анх 1966 онд тавьж БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1968 оны 04 дүгээр сарын 26-ны адрийн 136 тоот тогтоолыг үндэслэн “Улаанбаатарын илчит гуравдугаар станц”-ын захиргааг байгуулах тухай шийдвэр гарсан. Дулааны станцын анхны зуух 1968 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтанд орсноор нийслэл хотын хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр, 1974 оны 12 сарын 01-ний өдөр анхны турбин генераторыг ашиглалтанд оруулснаар 1975 он гэхэд 45 МВт цахилгаан эрчим хүч, 130 Гкал/ц дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны цахилгаан станц болсон. ДЦС-ын хүчин чадлыг 1976-1981 онд өргөтгөн өндөр даралтын станц баригдаж ашиглалтанд орсноор нийт цахилгаанаар 148 МВт, дулаанаар 485 Гкал/ц суурилагдсан хүчин чадалтай болсон.

“ДЦС”-3 ТӨХК-ийн станцын суурилагдсан хүчин чадлыг 2014 онд цахилгаанаар 50 МВт, дулаанаар 100 Гкал/ц-аар нэмэгдүүлснээр станцын хүчин чадал цахилгаанаар 198 МВт, дулаанаар 585 Гкал/ц болсон бөгөөд суурилагдсан хүчин чадлын хувьд ТЭХС-ийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 18%, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 35%-ийг 70/1350С температуртай горимоор хангаж 100 гаруй хэрэглэгчдийг технологийн уураар ханган ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 164 тоот тогтоолоор 100% Төрийн өмчит хувьцаат компани болон зохион байгуулагдсан.


ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВЬ

2001 онд




- Эрчим хүчний яам
- Төрийн өмчийн хороо
- Сангийн яам

2020 онд







- Эрчим хүчний яам
- ТӨБЗГ

2. “ДЦС-3” ТӨХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Цахилгаан станцуудын суурилагдсан хүчин чадал нийт 1,418.8 МВт байгаагаас “ДЦС-3” ТӨХК-ийн хүчин чадал 198 МВт буюу 14%-ийг эзэлж байна.



2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ДЦС-3” ТӨХК нь 3 алба, 7 хэлтэс, 10 цех, 4 хэсгээс бүрдсэн нэгжийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

➤ Захиргаа, хүний нөөцийн алба

Компанийн хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, нийгмийн баталгааг хангах, сургах хөгжүүлэх, ажлын үр дүнг үнэлж санал санаачилгыг дэмжиж ажиллах, дотоод хяналт үнэлгээний тогтолцоог сайжруулах, мэдээллийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах, хуулийн хүрээнд эрх зүйн акт боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлж, ажлын хариуцлага сахилга батыг сахиулах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

➤ Үйлдвэрлэлийн алба

“Эх орныг хөгжилд хөтлөх эрчим хүчийг бид бүтээнэ” хэмээх эрхэм зорилгыг үндэс болгон цахилгаан дулаан үйлдвэрлэх, хэрэглэгчдийг чанартай эрчим хүчээр тасралтгүй ханган, үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, станцыг эдийн засгийн үр ашигтай горимоор ажиллуулах, ТЭЗҮ-ийг тооцоолох, дээшлүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, тоноглолын горим тохируулгын ажлыг хийж, ашигтай ажиллуулах, цехүүдийн үйл ажиллагааг нэгтгэн удирдах, шуурхай ажиллагааг зөв зохион байгуулах зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна.

➤ Засвар хяналтын алба

Станцын үндсэн, туслах тоноглолын график их ба урсгал засварын ажлын нэгдсэн график гарган мөрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж, тоног төхөөрөмжид гарсан их хэмжээний гэмтлийг засварлах ажлын нэгтгэн зохион байгуулж, ашиглалтын хэсэгт хүлээлгэн өгөх ажлыг шуурхай зохион байгуулах үндсэн зорилготой.

➤ Санхүү бүртгэлийн хэлтэс

Компанийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа бүхий л ажил гүйлгээг санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэж, санхүүгийн тайлан гаргах, жилийн батлагдсан төсөв, төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж, судалгаа, шинжилгээ хийх, гадаад болон дотоодын хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, компанийн эд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан үр ашгийг бий болгох үйл ажиллагааг зохион байгуулна.

➤ Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс

Компанийн хэтийн болон ойрын бизнес төлөвлөгөөг мөрдөж байгаа норм, судалгаа шинжилгээн дээр үндэслэн бага зардлаар, үр ашигтай ажиллах зарчмыг баримтлан, холбогдох үзүүлэлтүүдээр боловсруулан батлуулж гүйцэтгэлд хяналт тавин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, үнэ тарифын санал боловсруулж шийдвэрлүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, орон тоо, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, төлөвлөх, холбогдох дүрэм, журмыг боловсруулах, норм

нормативыг боловсронгуй болгож, өртөг зардлыг хямдруулах ажил зохион байгуулах, их засвар, урсгал засварын материалын зарцуулалтанд тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулна.

➤ Хяналтын хэлтэс

Үйлдвэрлэлийн цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалтын тоноглол, дамжлага, ажлын байруудад хяналт тавих, барилга байгууламжуудыг угсрах, төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм, зааврууд, цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм (ААД) болон эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм (ТАД)-ийг мөрдлөг болгон уг дүрмээр батлагдсан цахилгаан, дулааны тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, химийн горимын биелэлтэнд хяналт тавих, үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл ахуйн норм, стандартын шаардлага хангуулах, хэмжилзүйн дотоод хяналтыг явуулах, Компанийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

➤ Техникийн бодлогын хэлтэс

Техникийн бодлогын хэлтэс (ТБХ) нь эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд нэгж тоноглолын ТЭЗҮ-г дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээг хийж, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээтэй уялдан суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх болон экологийн сөрөг нөлөөллийг бууруулах техник технологийн шинэчлэл, өөрчлөлтийн бодлогыг үе шаттайгаар боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг бусад алба, хэлтэс, цех нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.

➤ Хангамжийн хэлтэс

Харилцагч компаниудтай байнгын холбоотой ажиллаж, гадаад дотоод захиалгыг үндэслэн Компанийн хэмжээний бүх төрлийн түлш, шатахуун, материал сэлбэгийн захиалгыг жилийн хэрэгцээгээр хийж, төсөв төлөвлөгөөнд мөрдөж байгаа норм нормативыг үндэслэн тусгаж, жил бүр тогтоосон хугацаанд бэлтгэн нийлүүлэх, гэрээ хэлцэл хийх, дүгнэх, сэлбэг материалын судалгаа гаргаж, үлдэгдлийг хянана.

➤ Горим тооцооны хэлтэс

Үйлдвэрлэлийн найдвартай, үр ашигтай горим төлөвлөх, гүйцэтгэлийг тооцон гаргаж судалгаа, шинжилгээ хийн сайжруулах арга замыг тодорхойлон хэрэгжүүлнэ.

➤ Борлуулалтын хэлтэс

Эрчим хүч хэрэглэгч 100 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагатай “Эрчим хүч худалдах, худалдан авах” тухай гэрээ байгуулж эрчим хүчээр ханган, цахилгаан дулааны эрчим хүчний борлуулалтын орлогыг төвлөрүүлнэ.

➤ Үйлчилгээ аж ахуйн хэсэг

Компанийн нийтийн биеийн тамир спорт, соёл, олон нийтийн ажлыг зохион байгуулах, бие бялдарыг хөгжүүлэх спорт, нийгмийн идэвхийг өрнүүлж ажилчдын дунд уралдаан тэмцээн зохиох, ажлын байр болон ахуйн байрнуудын тохижилт, ариун цэвэр, эмх цэгцийг сайжруулах, ажилчдын ажлын хувцсыг цэвэрлэх, ажилчдыг орон сууцжуулах ажлыг зохион байгуулна.

➤ Эмнэлгийн хэсэг

Компанийн ажилтнуудад эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилж эрүүлжүүлэх, эрүүл мэндийн сургалт зохион байгуулна.

➤ Автын хэсэг

Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, засвар үйлчилгээ хийх, шаардлагатай тээврийн хэрэгслээр үйлчилнэ.

➤ Түлш дамжуулах цех

Уурхайгаас ирсэн нүүрсийг хүлээн авах, нүүрсний тоо, чанарт хяналт тавьж буулгах, нөөцлөх, зуухыг нүүрсээр тасралтгүй хангах үндсэн үүрэгтэй.

➤ Дунд даралтын зуухан цех

Түлш дамжуулах цехээс ирсэн нүүрсийг хүлээн авч технологийн боловсруулалтыг хийж, зуухны галын хотолд шатаан нүүрсний шаталтын дулаан энергийг ашиглан 39 ата даралттай, 440 градусын халуунтай хэт халсан уур боловсруулж турбинд цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх процессыг тасралтгүй хангах үүрэгтэй.

➤ Өндөр даралтын зуухан цех

Түлш дамжуулах цехээс ирсэн нүүрсийг хүлээн авч технологийн боловсруулалт хийж зуухны галын хотолд шатаан, нүүрсний шаталтын дулааны энергийг ашиглан 100 ата даралттай, 540 градусийн халуунтай усыг боловсруулж хэт халсан уураар турбиныг хангах үүрэгтэй.

➤ Дунд даралтын турбин цех

ДДЗ цехийн зууханд боловсруулагдсан хэт халсан уураар турбиныг ажиллуулж цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэгчдийг дулаан цахилгааны эрчим хүчээр тасралтгүй хангах, технологийн хэрэглээний уураар үйлдвэрүүдийг хангах, станцын дотоод хэрэгцээний барилга байгууламжийн хэрэгцээний халуун ус болон дулаацуулгыг тасралтгүй халааж хангах, үйлдвэрлэлийн гарч байгаа бохир болон хаягдал усыг зайлуулах үндсэн үүрэгтэй.

➤ Өндөр даралтын турбин цех

Үндсэн туслах тоноглолыг техникийн хүчин чадалд тохируулан эдийн засгийн үр ашигтай оновчтой горим сонгон ажиллуулах, цахилгаан дулааны хослон үйлдвэрлэл явуулан хэрэглэгчдийг эрчим хүчээр, станцыг техникийн усаар тасралтгүй найдвартай жигд хангах үндсэн үүрэгтэй.

➤ Цахилгаан цех

Цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, хуваарилан түгээх үүрэгтэй. Өндөр даралтын хэсгийн генераторын суурилагдсан хүчин чадал 150МВт, Дунд даралтын хэсгийн генераторын суурилагдсан хүчин чадал 48МВт. Станц нь Төвийн эрчим хүчний системтэй 35/110 килоВольтын шугамаар холбогдож 6/35/110 килоВольтын шугамаудаар хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангадаг.

➤ ДХХА цех

Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай үндсэн ба туслах тоноглолын 450 гаруй цахилгаан хаалт, 300 гаруй халууны хэмжүүр, 1200 гаруй даралт, зарцуулалт, төвшний хэмжүүр, 160 гаруй автомат, регулятор, шиберийн их болон урсгал засварыг графикийн дагуу чанартай хийж, ашиглалтын үед илэрсэн болон гарсан гэмтлүүдийг түргэн шуурхай устган, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль эрх зүйн хүрээнд станцын хэвийн найдвартай эдийн засгийн үр ашигтай ажиллагааг ханган ажиллуулах үндсэн үүрэгтэй.

➤ Хими цех

Техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан давсгүйжүүлсэн, химийн цэвэр болон зөөлөрсөн усаар станцыг тасралтгүй хангаж уур-ус, түлш, тосны чанарын нормыг хангуулах үүрэгтэй. 1 цагт 150 тонн давсгүйжуулсан ус, 120 тонн химийн цэвэр ус, 300 тонн зөөлөрсөн ус боловсруулах хүчин чадалтай.

➤ Засварын Цех

Станцын үндсэн туслах, галын тоноглолын бэлэн байдлыг хангаж, их, урсгал, гэмтэл устгалтын засварын ажлыг хийж гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

➤ Механик цех

Токарын бригад, Хийц сэргээн засах бригад, Сантехникийн бригад, Өргөх зөөх механизмийн бригад, Эргэх механизмийн бригад, Хүчилтөрөгч аж ахуй гэсэн 6 бригадтай үйл ажиллагаагаа явуулдаг. Тус цех нь 8 ИТА, 59 ажилтны бүрэлдэхүүнтэй.

➤ Уурын хэсэг

Станцаас гарч байгаа үйлдвэрийн уурыг өөрийн мэдлийн төв болон салбар, салаа шугам сүлжээгээр дамжуулан дулааны эрчим хүч худалдах, хэрэглэгчдийг технологийн уураар тасралтгүй найдвартай хангах үндсэн үүрэгтэй.

3.ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ


2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын 30 тоот тушаалаар 2020.01.08-ны өдөр батлуулан ажиллаж байгаад, COVID-19 цар тахлын улмаас эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг үндэслэн ТУЗ-ийн 27 тоот тогтоолоор 2020.10.27-ны өдөр батлуулан ЭХ-ний сайдын 239 тоот тушаалаар 2020.11.12-ний өдөр нэмэлт өөрчлөлтийг баталгаажуулж мөрдөн ажилласан.

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		Өөрчлөлт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биетээр	Хувиар	
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	сая.кВтц	1,054.3	1,031.7	1,050.1	18.4	1.7%	
	ДХЦЭХ	хувь	16.44	16.86	16.86	0.0	0.1%	
		сая.кВтц	173.3	173.9	177.1	3.2	1.8%	
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	сая.кВтц	881.0	857.8	873.0	15.2	1.7%
		ДЭХ	Гкал	2,214.2	2,323.3	2,369.4	46.1	1.9%
	Үнийн дүнгээр	ЦЭХ	сая.төг	91,363.3	93,787.0	94,778.4	991.4	1.0%
ДЭХ		сая.төг	24,517.7	27,285.7	27,260.4	(25.3)	-0.1%	
2	Нийт орлого	сая.төг	116,904.5	121,997.6	122,738.5	740.9	0.6%	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	115,881.0	121,072.7	122,038.8	966.1	0.8%	
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,023.5	924.8	699.6	(225.2)	-32.2%	
3	Нийт зардал	сая.төг	119,589.4	121,997.6	124,807.9	2,810.3	2.3%	
	Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг	303.7	332.9	336.5	3.6	1.1%	
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	834.4	703.7	829.1	125.3	15.1%	
4	Татварын өмнөх ашиг / алд	сая.төг	(2,684.9)	(0.0)	(2,069.4)	(2,069.4)		
5	Цэвэр ашиг / алдагдал /	сая.төг	(2,773.0)	(0.0)	(2,107.6)	(2,107.6)		
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	сая.төг	1.02	1.00	1.02	0.017	1.7%	
8	Нийт авлага	сая.төг	8,562.5	8,014.9	9,713.9	1,699.0	17.5%	
9	Нийт өглөг	сая.төг	34,060.3	30,364.7	30,494.1	129.5	0.4%	
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	12,209.4	10,738.9	10,764.4	25.5	0.2%	
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	21,850.9	19,625.8	19,729.7	103.9	0.5%	
10	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	сая.төг	14,452.0	17,387.8	21,326.3	3,938.5	18.5%	
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	994.0	996.0	995.0	(1.0)	-0.1%	
12	Нийт цалингийн сан	сая.төг	26,802.5	28,017.5	28,432.1	414.6	1.5%	
13	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	2,247.0	2,344.2	2,381.2	37.1	1.6%	


4.ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

2020 онд 1050.1 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 177.1 сая кВтц буюу 16.86%-ийг зарцуулан 873.0 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээсэн байна.

2020 оны ЦЭХ-ний боловсруулалт, түгээлт



2020 оны ЦЭХ-ний түгээлт 872.9 сая.квтц




ЦЭХ-ний боловсруулалт түгээлтийн талаар:

Боловсруулсан ЦЭХ-ийг төлөвлөснөөс 18.3 сая.кВтц буюу 101.8%-иар давуулан биелүүлж, өмнөх оны мөн үеэс 4.2 сая.кВтц-аар буурсан байна.


Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөснөөс 15.2 сая.квтц буюу 101.8%-иар, диспетчерийн графикийг 101.4%-иар тус тус давуулан биелүүлж , өмнөх оны мөн үеэс 7.9 сая.кВтц-аар буурсан үзүүлэлттэй байна.

ДЭХ-ний түгээлтийн талаар: 2020 онд усаар 2,112.3 мян.Гкал, уураар 257.0 мян.Гкал нийт 2,369.4 мян.Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөгөөг 46.0 мянган Гкал буюу 101.9%-аар, 2019 онтой харьцуулахад 155.2 мянган Гкал- аар буюу 107.0%-аар тус тус давж биелсэн.

ДЭХ-ний түгээлт /мян.Гкал/




2020 оны ДЭХ-ний гүйцэтгэл 2369.4 мян.Гкал



ДХЦЭХ-ний талаар

ДХЦЭХ-ний хэмжээ 2020 онд 177.1 сая кВт.ц буюу 16.86% байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад ижил түвшинд, өмнөх оноос 0.42%-аар нэмэгдсэн байна.


ДХЦЭХ-ний хувь хэмжээ өмнөх оноос 0.42%-аар нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар авч үзье. Доорх графикт 2019 болон 2020 оны ДХЦЭХ-ний хувь хэмжээг сар бүрээр харууллаа.



Графикаас харахад 01-06 сар болон 10, 12-р саруудад ДХЦЭХ-ний хэмжээ нэмэгдсэн байна. Тус саруудад ДХЦЭХ-ний хэмжээ нэмэгдэхэд ТБЭХС-ийн хэрэглээний бууралт болон сүлжээний усаар түгээх дулааны ачааллын өсөлт шууд нөлөөлсөн. Тухайлбал ТБЭХС-ийн хэрэглээний бууралтаас шалтгаалан 4, 5 болон 7-р саруудад цахилгаан ачааллыг 3-12%-аар бууруулан ажилласан. Сүлжээний усаар түгээх дулааны ачаалал өмнөх оноос 155.2 мян.Гкал буюу 7%-аар нэмэгдсэн.

Сар бүрээр ЦЭХ боловсруулалт болон ДЭХ түгээлтийг авч үзье.

ЦЭХ боловсруулалт болон ДЭХ түгээлтийн хэмжээг сар бүрээр өмнөх онтой харьцуулан харууллаа.




Графикаас харахад өвлийн оргил ачааллын саруудад ЦЭХ боловсруулалтын өсөлтөөс ДЭХ түгээлтийн өсөлт илүү нэмэгдсэн нь харагдаж байна. 2020 онд бууруулан хөргөх төхөөрөмжөөр 189.2 мян.тн уур ашиглан ДЭХ түгээсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 29.6 мян.тн буюу 18.5%-аар нэмэгдсэн байна.

Жишмэл түлшний талаар

Үйлдвэрлэлийн явцад 687.3 мянган тонн жишмэл түлш зарцуулсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 16.3 мянган тонн жишмэл түлш хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь цахилгаан болон дулааны эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэнээр цахилгаанд зарцуулах жишмэл түлш 8.1 мянган тонн, дулаанд зарцуулах жишмэл түлш төлөвлөснөөс 8.2 мянган тонноор тус тус нэмэгдсэн.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт



Жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 310.76 гр/кВтц, дулаанд 175.59 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 3.94 гр/кВтц-аар, дулаанд 0.04 кг/Гкал-аар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс цахилгаанд 3.51 гр/кВтц-аар, дулаанд 0.41 кг/Гкал-аар тус тус буурсан байна.



Үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд ЭХЯ болон ЭХЗХ-оос хамтран 2020 оны 09-р сараас тодотгол хийсэн бөгөөд энэхүү тодотголд жишмэл түлшний хувийн зарцуулалтыг анхны төлөвлөлтөөс 8.1 гр/квт-аар бууруулан 306.8 гр/квтц байхаар төлөвлөсөн. Төлөвлөгөөнд тусгагдсан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл түгээлтийн хэмжээнээс авч үзэхэд жишмэл түлшний хувийн зарцуулалтыг (цахилгаан) дээрх тодотгосон төлөвлөлтийн хэмжээнд ажиллах боломжгүй.

Нийт орлого

2020 оны байдлаар нийт 122,738.5 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөөг 740.8 сая төгрөг буюу 0.6%-иар давуулан биелүүлж 2019 онтой харьцуулахад 5.8 тэрбум төгрөг буюу 5.0%-иар өссөн.



Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөснөөс 991.4 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөснөөс 25.5 сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлого /тэрбум.төгрөг/



Нийт зардал


Нийт зардал /тэрбум төгрөг/



2020 онд нийт 124.8 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж төлөвлөснөөс 2.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд: ЦЭХ, ДЭХ-ний түгээлт нэмэгдсэнтэй холбоотой түлшний зардал 954.5 сая төгрөг, үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдсэнээр элэгдлийн зардал 1,534.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн.

Ашиг алдагдал

Ашиг, алдагдал /сая.төгрөг/



2020 онд татварын өмнөх дүнгээр 2069.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба энэ нь өмнөх оноос 615.5 сая төгрөгөөр алдагдал буурсан үзүүлэлттэй байна.

2020 онд станцын ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 78.43 төгрөг байгаа ба 1 кВтц ЦЭХ-ийг дунджаар 108.56 төгрөгөөр борлуулж, нэгжээс 30.13 төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлтээс 26,049.6 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 23,318.4 төгрөг байгаа ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар 11,505.3 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 11,813.1 төгрөгийн, нийт ДЭХ үйлдвэрлэлээс 27,989.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нэгжийн өөрийн өртөг

Цахилгаан эрчим хүчний өөрийн өртгийг төлөвлөснөөс 2.61 төгрөгөөр нэмэгдэж, дулааны эрчим хүчний өөрийн өртгийг 29.47 төгрөгөөр бууруулж ажилласан

Борлуулалтын орлогын нэг төгрөгт ноогдох зардал

Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал 1.02 төгрөг гарч төлөвлөсөн хэмжээнээс 0.02 мөнгөөр нэмэгдсэн.

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хийгдэж дууссан ба 2019 онд эхлүүлсэн үнсэн сангийн ажил энэ жил бүрэн дуусч, өмнөх онд төлөвлөсөн 4 тэрбум төгрөгийн энэ жилийн гүйцэтгэл дээр нэмэгдэж нийт 21,235.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан. Үүнд:

- Үндсэн тоноглолын их засварт 5,406.6 сая төгрөг зарцуулж 337.6 сая төгрөгөөр, туслах тоноглолд 2,637.5 сая төгрөг зарцуулж 451.3 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн.
- ТЗБАХ-ний 7 ажилд 12,433.5 сая төгрөг зарцуулж 625.8 сая төгрөг хэмнэсэн.
- Хөрөнгө оруулалтын 21 ажилд 822.4 сая төгрөг зарцуулсан.

Авлага




2020 оны эцэст авлагын үлдэгдэл 9,713.8 сая төгрөг болж оны эхнээс 1,151.3 сая төгрөгөөр буюу 13.4 хувиар өссөн байна. Үүнд:

Оны эхнээс үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасах болсонтой холбоотойгоор татварын авлага 831.2 сая төгрөгөөр, Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс Засгийн газрын 211 тогтоолын дагуу ААН, иргэдийн цахилгаан, дулаан, уурын төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотой Уурын болон өөрийн щиний борлуулалтын орлого Засгийн газраас төлөгдөөгүйгээс 427.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад авлагыг 107.4 сая төгрөгөөр бууруулсан.

Өр төлбөр

Нийт өглөг /сая.төг/




2020 онд нийт өр төлбөр 30.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны гүйцэтгэлээс 3.6 тэрбум төгрөгөөр буурсан. Богино хугацаат өглөгийн үлдэгдэл 10,764.4 сая төгрөг болж зорилтыг 1,445.0 сая төгрөгөөр бууруулан биелүүлж ажилласан.

Орон тоо, цалингийн сан

2020 оны байдлаар орон тооны гүйцэтгэлээр 995 гарч 1 орон тоогоор хэмнэж ажилласан.

Дундаж цалин /мянган.төг/



Цалингийн санд 28,017.5 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 28,432.1 сая төгрөг зарцуулж, 1.5% хувиар нэмэгдсэн.

Нэг ажилтны дундаж цалин гүйцэтгэлээр 2,381,248.0 төгрөг байгаа нь төлөвлөснөөс 37,077.0 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	2020.01.01	2020.12.31
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,152,637.0	1,032,067.5
Дансны авлага	8,409,965.7	8,716,333.2
Татвар, НДШ-ийн авлага	53,338.8	884,576.9
Бусад авлага	99,223.0	112,954.4
Бараа материал	11,872,190.6	9,377,755.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,905,738.6	1,081,654.8
Эргэлтийн хөрөнгийн дүн	26,493,093.7	21,205,342.8
Үндсэн хөрөнгө	189,783,675.5	225,691,789.2
Биет бус хөрөнгө	39,076,051.7	39,095,674.6
Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765.2	204,765.2
Дуусаагүй барилга	133,251.1	12,782,891.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	229,197,743.4	277,775,120.4
Нийт хөрөнгийн дүн	255,690,837.1	298,980,463.2
Өр төлбөр		
Дансны өглөг	9,939,769.9	1,187,455.0
Цалингийн өглөг	-	2,928,119.1
Татварын өр	139,340.8	148,945.7
Богино хугацаат зээл	1,779,506.4	5,778,140.8
Хүүний өглөг	155,368.6	150,742.9
Урьдчилж орсон орлого	4,819.3	276,688.5
Бусад богино хугацаат өр төлбөр	190,627.2	294,344.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,209,432.3	10,764,436.0
Урт хугацаат зээл	17,045,288.1	15,267,147.2
Хойшлогдсон татварын өр	1,687,677.1	1,720,580.9
Бусад урт хугацаат өр төлбөр	3,117,949.2	2,741,954.6
Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,850,914.3	19,729,682.7
Өр төлбөрийн нийт дүн	34,060,346.6	30,494,118.7
Эзэмшигчийн өмч		
Өмч: - төрийн	99,362,783.0	99,362,783.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	109,442,769.3	158,066,844.1
Эздийн өмчийн бусад хэсэг	38,694,650.0	38,753,450.0
Хуримтлагдсан ашиг	(25,869,711.8)	(27,696,732.6)
Тайлангийн үеийн ашиг	-	(2,107,609.5)
Өмнөх үеийн ашиг	(25,869,711.8)	(25,589,123.1)
Эздийн өмчийн дүн	221,630,490.4	268,486,344.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	255,690,837.1	298,980,463.2

ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	115,880,988.6	122,038,838.3
Борлуулалтын өртөг	108,898,851.8	113,936,670.3
Нийт ашиг(алдагдал)	6,982,136.7	8,102,168.0
Түрээсийн орлого	82,750.5	105,148.7
Хүүний орлого	170,282.5	52,710.4
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	736,116.5	515,458.9
Орлогын дүн	989,149.5	673,318.0
Борлуулалт, маркетингийн зардал	251,549.3	195,737.2
Ерөнхий ба удирдлагын зардал	7,333,365.5	7,677,493.5
Санхүүгийн зардал	392,050.9	694,858.8
Бусад зардал	2,711,551.4	2,279,024.7
Зардлын дүн	10,688,517.1	10,847,114.3
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	6,933.1	23,524.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	25,384.7	(21,331.3)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Олз, гарзын дүн	32,317.8	2,193.6
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(2,684,913.1)	(2,069,434.7)
Орлогын татварын зардал	88,048.0	38,174.8
Татварын дараах ашиг (алдагдал)	(2,772,961.1)	(2,107,609.5)
Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,772,961.1)	(2,107,609.5)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдс ан ашиг	Нийт дүн
2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	138,057,433.0	109,828,620.3	0.0	-23,482,601.7	224,403,451.5
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	385,850.9	385,850.9
Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	-2,772,961.1	-2,772,961.1
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	-38,694,650.0	0.0	38,694,650.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	-385,850.9	0.0	0.0	-385,850.9
2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,783.0	109,442,769.3	38,694,650.0	-25,869,711.8	221,630,490.4
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	280,588.7	280,588.7
Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	-2,107,609.5	-2,107,609.5
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	58,800.0	0.0	58,800.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	48,624,074.8	0.0	0.0	48,624,074.8
2020 оын 12 сарын 31-р үлдэгдэл	99,362,783.0	158,066,844.1	38,753,450.0	-27,696,732.6	268,486,344.5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	-	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	115,538,050.6	124,131,048.4
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	114,683,081.6	123,806,909.5
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	231,267.5	204,968.2
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	623,701.5	119,170.8
Мөнгөн зарлагын дүн (-)	101,582,948.1	111,375,816.0
Ажиллагчдад төлсөн	25,061,507.8	21,875,811.5
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,475,500.0	7,172,061.3
Бараа материал худалдан авахад төлсөн	47,958,393.7	60,570,547.6
Ашиглалтын зардалд төлсөн	1,677,413.6	2,195,818.2
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,333,802.2	8,975,724.1
Хүүний төлбөрт төлсөн	68,229.6	401,839.4
Татварын байгууллагад төлсөн	9,060,898.1	8,401,826.5
Даатгалын төлбөрт төлсөн	84,726.0	76,839.9
Бусад мөнгөн зарлага	1,862,476.9	1,705,347.5
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,955,102.5	12,755,232.4
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	170,282.5	52,710.4
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	170,282.5	52,710.4
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	14,620,848.2	16,715,097.1
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,527,483.2	16,715,097.1
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	93,365.0	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,450,565.7)	(16,662,386.7)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	-	5,000,000.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	5,000,000.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	213,415.2	1,213,415.2
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	213,415.2	1,213,415.2
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Бусад	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(213,415.2)	3,786,584.8
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(708,878.4)	(120,569.5)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,861,515.4	1,152,637.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,152,637.0	1,032,067.5

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

№	Санхүүгийн харьцаанууд	2018.12.31	2019.12.31	2020.12.31	Өөрчлөлт
1	Хөрвөх чадварын шинжилгээ				
	Цэвэр эргэлтийн хөрөнгө сая.төг	12,616.8	14,283.7	10,440.9	-3,842.8
	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	1.24	0.80	1.00	0.20
	Эргэлтийн харьцаа	2.53	2.17	1.97	-0.20
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	8.13%	10.36%	7.09%	-0.03
	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.05	0.06	0.03	-0.02
2	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ				
	Бие даах чадварын коэффициент	0.87	0.87	0.90	0.03
	Санхүүгийн хамаарлын коэффициент	1.14	1.15	1.11	-0.04
	Зохицуулалтын коэффициент	-0.89	-0.87	-0.92	-0.05
3	Эргэцийн шинжилгээ				
	Авлагын эргэц (удаа)	13.39	13.53	12.56	-0.97
	Авлагын эргэц (өдөр)	26.89	26.60	28.65	2.05
	Нөөцийн эргэц (удаа)	10.12	9.17	12.15	2.98
	Нөөцийн эргэц (өдөр)	35.59	39.25	29.63	-9.62
	Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа)	5.38	4.37	5.76	1.38
	Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр)	66.97	82.30	62.55	-19.75
	Өрийн харьцаа	0.13	0.13	0.10	-0.03
	Үйл ажиллагааны цикл	62.48	65.85	58.29	-7.56
4	Бүтээмжийн шинжилгээ				
	Хөдөлмөрийн бүтээмж	112,770.3	116,580.5	122,775.5	6,195.0
	Үндсэн хөрөнгийн ачаалал /фонд өгөмж/	0.57	0.61	0.54	-0.07
	Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент	0.00	-0.01	-0.01	0.00
5	Мөнгөн урсгалын шинжилгээ				
	Ажлын капитал ба борлуулалтын харьцаа	0.11	0.12	0.09	-0.04
	Ажлын капитал ба хөрөнгийн харьцаа	0.05	0.06	0.03	-0.02
	Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа	0.95	1.00	1.02	0.02
	Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа	0.41	0.45	0.42	-0.04
	Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа	0.87	0.88	0.91	0.04
6	Ашигт ажиллагааны шинжилгээ				
	Нийт ахиуц ашиг	7.38%	6.03%	6.64%	0.61%
	Үйл ажиллагааны ахиуц ашиг	-0.93%	-2.32%	-1.70%	0.62%
	Цэвэр ахиуц ашиг	-0.96%	-2.39%	-1.73%	0.67%
	Нийт хөрөнгийн өгөөж	-0.42%	-1.08%	-0.70%	0.38%
	Өөрийн хөрөнгийн өгөөж	-0.48%	-1.25%	-0.78%	0.47%



5.ХҮНИЙ НӨӨЦ

2020 онд компанийн өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдсан хүний нөөцийн удирдлагын цогц арга барилыг хэрэгжүүлэх, ажилчдын нийгмийн баталгааг хангах, тэднийг сургаж хөгжүүлэх, ажлын үр дүнг үнэлж санал санаачилгыг дэмжиж ажиллах, ажлын бүтээмж, соёлыг сайжруулах, хүний

нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа эрх зүйн үндэслэлтэй шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээлэл зөвөлгөө зөвлөмжөөр хангах, хяналт тавьж ажиллах, ажлын хариуцлага сахилга батыг сахиулах, олон нийттэй харилцах, үндсэн чиг үүргээ ханган ажиллаа.

“ДЦС-3” ТӨХК 2020 онд дансны тоогоор нийт 996 ажилтантай ажиллалаа. Үүнээс: 225 нь ИТА, 771 нь ажилтан байна. Нийт ажилтнуудын 55% нь дээд, 12% нь тусгай дунд, 30% нь бүрэн дунд боловсролтой байна. Нийт 996 орон тооны 241 ажилтан буюу 24.1%-ийг эмэгтэйчүүд, үлдсэн 75.9%-ийг эрэгтэйчүүд эзлэж байна.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд сул орон тооны нөхөн хангалтыг оновчтой зохион байгуулах чиглэл барьж ажилласан. Шинээр орсон ажилчдын 74% нь мэргэжлийн дээд боловсролтой, нийт 84% нь тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг бүрэн хангасан хүмүүс байна. Ажилтан албан хаагчдын албан тушаалын карьер хөгжлийг бодлогоор дэмжиж, мерит зарчмын дагуу ажилтнаас ИТА-д дэвшсэн 8 ажилтан байна.



Сургалтын үйл ажиллагаа

2020 оныг Эрчим хүчний салбарын хэмжээнд “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих жил”-болгон зарласан бөгөөд олон үйл явдал өрнөсөн их ажлын жил байлаа. Бид энэхүү ажлын хүрээнд үндсэн 3-н чиглэлд 33 ажил төлөвлөж 90.9% гүйцэтгэлтэй амжилттай хэрэгжүүлж хүний нөөцийн хөгжлийн гол үзүүлэлт болох сургалт хөгжлийн чиглэлд мөн шинээр бүрдүүлэх хүний нөөцийн хангалтанд онцгой анхаарал тавьж шинэлэг бөгөөд үр дүнтэй арга барилыг нэвтрүүлэн хэрэгжүүллээ.

Сургалт хөгжлийн бодлогын хүрээнд ИТА, ажилчдын ерөнхий чадамжийн сургалтыг зохион байгуулах, ИТА нарыг аттестатчилах, хувийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан

хэрэгжүүлэх, байгууллагын мэдлэгийн санг бүрдүүлэх, өргөжүүлэх чиглэлд түлхүү анхаарч ажилласан. Сургалтын төлөвлөгөөг 84% биелүүлж 81 сургалт, 8 сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан нийт давхардсан тоогоор 1639 хүн хамрагдсан байна.

Сургалтын үйл ажиллагаанд гарсан эерэг үзүүлэлтүүд:

- Нэг ажилтанд ногдох сургалтын цаг удирдлагад 17.6, ИТА-д 10.1, ажилтанд 2.6 дахин буюу нийт ажилтанд 2 дахин нэмэгдсэн.
- Байгууллага дээрх сургалтанд хамрагдсан ажилтны тоо /лекцэнд хамрагдсан ажилтныг хассан дүнгээр/ 6.3 хувиар өссөн.

Сургалтын үйл ажиллагааны үзүүлэлтүүд:

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2020	2019	2018
1	Сургалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	Төлөвлөгөө	тоо	73	66	62
		Гүйцэтгэл		61	61	58
		Биелэлт	%	84%	93.7%	93.6%
2	Сургалтын зардал	Төлөвлөгөө	сая.төг	166.5	132.2	135.1
		Гүйцэтгэл		140.2	158.9	124.2
		Нэг ажилтанд ногдох	мян.төг	85.5	29.6	50.6
3	Сургалтанд хамрагдсан ажилтнууд	Нийт	тоо	1639	4464	2672
		Удирдлага		62	127	91
		ИТА		631	890	870
		Ажилчид		946	3447	1711
4	Сургалт зохион байгуулсан газар	Гадаадын сургалт	тоо /давхардсан/	0	21	16
		Сургалтын байгууллагад		108	188	192
		Байгууллага дээр		1531	4255	2464
5	Нэг ажилтанд ногдсон сургалтын дундаж цаг	Нийт	цаг	12.4	6.2	8.4
		Удирдлага		14	11.9	14.3
		ИТА		12	10.9	10.3
		Ажилчид		13	5	7.1

Уламжлал болгон 13 дахь удаагаа зохион байгуулсан эрдэм шинжилгээ онол практикийн бага хурлыг 2020.09.30 ны өдөр ШУТИС ЭХС-тай хамтран “ИНЖЕНЕРИЙН ЧАДВАР-ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” сэдэвтэйгээр амжилттай зохион байгууллаа. Хуралд компанийн инженер техникийн ажилчид, эрдэмтэн багш нар, оюутнуудын 80 гаруй төлөөлөл оролцож 34-н илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл ирүүлсэн байна.

ИТА-аттестатчилал

Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан Хүний нөөцийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 85 тоот тушаалаар батлагдсан Эрчим хүчний ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах журмын 2.2.6 дахь заалтуудыг үндэслэн зохион байгуулагдсан Инженер техникийн ажилтан, албан хаагчдын онолын мэдлэгийн түвшинг үнэлж аттестатчилах ажлыг ЭХХТ-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран 2020 оны 10 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулсан ба ИТА нарын дундаж үнэлгээ 70.3%-тай байна.

6.ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЛААР



ДЦС-3 ТӨХК нь 2020-2021 оны өвлийн бэлтгэл хангаж хийх ажлын хүрээнд хийгдэх ӨДХ-ийн бүрэн зогсолтын засварын ажил амжилттай хийгдлээ. ДДС-ын бүрэн зогсолтын ажил төлөвлөгөөний дагуу 100%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан байна.

Дулаанжуулалтын тоноглолуудын их засварууд, сүлжээний усны коллекторын их засвар бүрэн хийгдэж хотын сүлжээнд залган ажиллаж байна. Үндсэн тоноглолын их болон дунд засварын төлөвлөгдсөн 7 тоноглолын засвар бүрэн хийгдэж дууссан.

- Өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт

2020-2021 оны өвлийн бэлтгэл хангах ажлыг хангах нийт 40 ажил бүрэн хийгдэж дууссан байна. Нийт гүйцэтгэл – 100% байна.

- Их засвар

Тус станц нь 2020 – 2021 оны өвлийн бэлтгэл хангаж 4 үндсэн тоноглолд их засвар, 3 үндсэн тоноглолд дунд засвар, 107 туслах тоноглолд их засвар хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэл-100%.

а. Үндсэн тоноглолын засвар :

№	Тоноглолын нэр	Төлөвлөсөн хугацаа		Засварын хугацаа		Гүйцэтгэл	
		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Эхэлсэн	Дууссан	Хувь	Гүйцэтгэгч
1	Зуух №6 их засвар	01/VI	01/IX	25/V	1/IX	100%	Эрчим дөл ХХК
2	Зуух №9 их засвар	10/V	25/IX	15/V	25/IX	100%	СММ ХХК
3	Зуух №10 их засвар	15/V	15/IX	11/V	15/IX 22/IX	100%	МЭЗ ХХК, Мон Илч ХХК
4	Зуух №3 нэмэлт халах гадаргуу солих	15/VI	01/IX	15/VI	15/VIII	100%	Энергосервис монтаж ХХК
5	Зуух № 4 нэмэлт халах гадаргуу солих	15/VI	01/IX	15/VI	15/VIII	100%	Мон Илч ХХК
6	Турбингенератор №4 ажлын хүрээм солих	15/IV	15/СШ	15/IV	15/VI	100%	Засварын цех
7	Турбингенератор №5 их засвар	15/VIII	15/XI	1/VIII	12/XI	100%	Эрчим маш ХХК

б. Туслах тоноглолын их засвар:

Нийт төлөвлөсөн 107 туслах тоноглолд их засварын ажил бүрэн хийгдэж дууссан.

- **Техник зохион байгуулалт арга хэмжээгээр хийгдэх ажил:**

ТЗБАХ-ээр 8382,14 сая төгрөгийн нийт 6 ажил төлөвлөснөөс 5 ажил бүрэн хийгдэж, 1 ажил бүрэн дуусаагүй техникийн комисс ажиллаж хүлээж авах ажил цар тахал хөл хорионоос шалтгаалж түр хойшлогдоод байна. Гүйцэтгэл- 99.7%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/	Гүйцэтгэл
1	Үнсэн сан шинээр барих	8,000.0	Үнсэн сангийн ажил дууссан туршилт тохируулгын ажил үлдсэн , цаг үеийн байдлаас улсын комисс ажиллуулахыг түр хойшлуулсан байгаа. Гүйцэтгэл 98%
2	Хөргөх цамхаг №2-ын усны хатуулаг бууруулах	61.8	Хөргөх цамхаг №2-ын усыг зуухны смений баканд өгч хүйтэн усаар сэлгэх схемийн өөрчлөлт хийж хатуулгийн хэмжээг бууруулсан.
3	Станцын гэрэлтүүлгийг үе шаттай сүүлийн үеийн LED прожектороор солих	78.9	Цехүүдийн улайсах болон люминисцент гэрэлтүүлэгчийг 755 ширхэг LED гэрлээр сольж чадлын зөрүүгээр ЭХ хэмнэж байна.
4	Турбины роторын стэнд шинээр хийх	113.7	12, 25, 50 МВт-ын турбины ротор засварлах төхөөрөмж хийсэн.
5	БКЗ 220-100 маркийн зуухыг ХБУШ-д шилжүүлэх зураг төсөл хийх	105.0	Зураг, төсөл хийлгэх ажил дууссан. Тоноглолын хүчин чадал нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх боломжтой болсон.
6	Зуухнуудын МВ-н а4жлын хүрз, плитаг элэгдэлд тэсвэртэй материалаар хийх /60 ширхэг/	76.5	Гадаадаас олдоц ховор өндөр үнэтэй авдаг байсан бөгөөд олдохгүй тохиолдолд засварын хугацаа, зуухнуудын хэвийн найдвартай ажиллагааг хангасан.
НИЙТ ДҮН		8,435.9	

- Хөрөнгө оруулалтаар хийх ажил:

Хөрөнгө оруулалтаар 103.1 сая төгрөгийн 5 багц ажил хийхээр төлөвлөсөн. 5 ажил бүрэн хийгдэж дууссан байна. Гүйцэтгэл – 100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөсөн хөрөнгө /сая.төг/	Гүйцэтгэл
1	ӨДХ К№9,10 ТГ№5 болон ӨДХ–н туслах тоноглолын хяналтын дэлгэц 4 ширхэг /42 болон 32 инч/	9.30	Туслах тоноглолуудын хяналт удирдлагын системийг сайжруулж компьютерийн удирдлагад шилжүүлэх ажлын хяналтын дэлгэц болгон ашиглаж байна.
2	TESTO-350 хийн хэмжүүрийн анхдагч гар худалдаж авах	13.0	Зуухнаас гарч байгаа утааны хий дэх хорт бодисуудыг хэмжих, горимын хэмжилт , тохируулах ажилд ашиглаж байна.
3	Металл болон гагнуурын оёдлын дотоод согог хэмжигч, ханын зузаан хэмжих багаж	70.0	Хэт авианы багаж, ханын зузаан хэмжигч багаж авсан. Эдгээр нь МСГЛ-ын үзлэг хийдэг нэн шаардлагатай, нарийн хэрэглээний багаж юм
4	Мотоцикл	3.5	Харуулын хэсэг эргэлт, үзлэг шалгалт цаг алдалгүй хурдан шуурхай хийдэг болсон.
5	Компьютер, Принтер /3ш/	7.3	3 ширхэг принтер авсан. Тайлан мэдээ гаргахад хүндрэлгүй болсон.
НИЙТ ДҮН		103.1	

7.ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ



“ДЦС-3” ТӨХК-ийн 2032 он хүртэл баримтлах техникийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу 2020 онд төлөвлөгдсөн ажлуудыг хийсэн.

1. Шинэ үнсэн барих ажил

2020 онд компанийн техникийн бодлогын хүрээнд хийгдэж байгаа шинэ үнсэн сан барих ажлыг барилга угсралтын ажлын үед бороо их орсон, хөрсний ус дээшилсэн зэрэг бэрхшээлүүд их байсанч гэсэн тухай бүрт нь шийдвэрлэж энэ төслийн ажлыг зураг төсөвийн бүрэн хийж дуусгасан бөгөөд техникийн комисс ажиллахад бэлэн болсон байна.



“ДЦС-3” ТӨХК-ийн шинээр барьж байгаа үнсэн сангийн ажлын зураг төсвийг “Усны Эрчим” ХХК боловсруулсан ба ажлын зураг, төслийг холбогдох Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтэс, Нийслэлийн онцгой байдлын газартай тус тус оруулж зөвшилцөн, зөвшөөрөл аван ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төв екпертиз хийж баталсан.

Тус ажлыг гүйцэтгэхээр “Комфорт Импэкс” ХХК, Электрик Ком ХХК-ийн түншлэлтэй компани 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс гэрээ байгуулж улмаар тус бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн.

“Шинээр байгуулж байгаа “Үнсэн сан №6”-ын үндсэн үзүүлэлтүүд:

- Ашиглалтад орох огноо: 2020.11.18
- Үнсэн сангийн өндөр: 11 метр /ёроол 1274.0 м, хяр 1287.0 м/
- Далангийн налуу, хярын өргөн: Гадна 1/2, дотор 1/2.5, өргөн 6 м
- Үнсэн сангийн эзлэхүүн: 800,638 м³ (1284.5 м-д хүртэл дүүргэх үед)
- Үнсэн сангийн ус ашиглалт: 2 ширхэг шандорын худагтай
- Үнсэн сангийн талбай: 9.3 га газар

Үнсэн сан №6-ыг барихаар төлөвлөж байсан газарт бусад гадны аж ахуй нэгжүүд хэт тулгаж барилга байгууламж, хашаа барьсан нь шинэ үнсэн санг тооцоолсон зай талбайд барих

боломжийг хаагдуулж байсан тул шинэ үнсэн сангийн багтаамжийг нэмэгдүүлж ашиглалтын хугацааг уртасгах талаар зураг төсөв зохиогч, захиалагч, гүйцэтгэгч талууд удаа дараа харилцан зөвлөлдөж, анхны зураг төсөлд үнсэн сангийн дотор талын налуу 1/3, гадна налууг 1/2 байхаар хийснийг өөрчилж, дотор талын налууг 1/2.5 болгох, далангийн өндрийг 2,0 метрээр өндөрсгөх, үнсэн сангийн эзэлхүүнийг төсөвлөсөнөөс 160,000 куб.метрээр нэмэгдүүлж, 800,000 куб.метр болгон ашиглалтын хугацааг уртасгах шийдлийг зурагт тусгуулан холбогдох төрийн болон хяналтын байгууллагуудаар хянуулан батлуулж, үнсэн санг шинээр байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



- Үнсний хуучин шугам шилжүүлэх ажил
- Шандорын худгаас тунгаагдсан усны далан хүрэх 800мм-н хоолойн угсралт
- Далангийн овоолго, далан байгуулалтын ажил
- Шандорын худгууд болон гүүрэн байгууламжийн ажил
- Үнсэн сангийн шугам хоолойн угсралтын ажил
- Сангийн доторлогооны ажил
- ЦДАШ-ын трассыг өөрчлөх ажил
- Хяналтын худаг байгуулах ажил ажлуудыг хийлгэсэн.



Давуу талууд:

- ✓ 5 давхар геомембрамтай учир хөрс, усны бохирдол үүсгэхгүй

- ✓ Хяналтын гаргаж өгсөнөөр шинжилгээг хийж хянах боломжтой.
Зураг төсвийн дагуу хийж дууссан техникийн комисс ажиллаж хүлээн авах ажил үлдээд байна.

1. Станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төсөл

Станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн хүрээнд шаардлагатай мэдээллүүдийг тухай бүрт боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Эрчим хүчний яам болон ОХУ-ын Интер РАО экспорт компанийн мэргэжилтнүүдэд гарган өгч ажилласан.

Төслийн нэгжтэй хамтран бэлгэл ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

2. Өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх төсөл

“Дулааны III цахилгаан станц” ТӨХК-ийн өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 309 дугаар тогтоол гарсан.

Үүнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд зээлийн материал бүрдүүлж Хөгжлийн банканд зээлийн хүсэлт гаргасан. ЭХЗХ-оос Эрчим хүчний барилга байгууламж барих-эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл авахаар E-License цахим системд материал бүрдүүлж баталгаажуулсан.

Мөн шинэ техник технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн судалгааны ажил хийсэн Үүнд:

- БКЗ-100-220/4С зуухыг “Нам температурын хурдасгасан буцламтгай үет шаталт”-ын \ХБУШ\ технологид шилжүүлэх техникийн шийдэл
- ДЦС-3 ТӨХК-ийн кабелийн аж ахуйн тухай судалгаа
- IGCC технологи, шинэ төрлийн түлш бэлтгэл
- Хуучин үнсэн санг сэргээн ашиглах технологи, арга зам зэрэг судалгааны ажлууд хийсэн байна.

БКЗ-100-220/4С зуухыг “Нам температурын хурдасгасан буцламтгай үет шаталт”-ын \ХБУШ\ технологид шилжүүлэх техникийн шийдэл

ӨДХ-н зуухнуудын хувьд 1996-2000 оны хооронд зуух № 7,8,11,13 –р зуухнуудад өөрчилөлт хийж зуух№9-г хуучин технологээр нь сэргээснээс бусдаар дорвитой шинэчилэл хийгдээгүй. Ялангуяа зуух№ 10,12 анх ашиглалтанд орсноос хойш төлөвлөгөөт засварууд л хийгдэж тоноглолын шинэчилэл, технологийн өөрчилөлт хийгдэлгүй 40 гаруй жил ажиллаж байна. Зуухнууд хуучирсан засвар ашиглалтын хэт өндөр зардалтай, жилд зогсолтгүй ажиллах чадвар багатай, байгал орчинд эерэг бус нөлөөлөл өндөртэй, төслийн ачааллынхаа 75%-р ажилладаг үндсэн хүндрэлүүд байна. Иймээс цаашид Техникийн бодлогын хүрээнд төлөвлөгөөтэй ажил зохион байгуулах шаардлагатай Энэ үүднээс БКЗ-220-100 маркийн зууханд гарч байгаа дээрхи хүндрэлүүдийг багасгах зорилгоор энэ онд хийгдсэн нэг судалгаа, шийдэл боловсруулсан ажил бол зуухны шаталтын технологийг өөрчилсөн “Нам температурын хурдасгасан буцламтгай үет шаталт “-ын \ХБУШ\ технологийг хэрэгжүүлэх техникийн зураг боловсруулж бэлэн болгох, экспертизээр батлуулах, гарах зардлыг тооцож төсөв хийж баталгаажуулах ажлыг хийсэн.

Цахилгаан байгууламжийн шинэчлэл

ТУНСтанцын 6/0.4 кВ-ын хуваарилах байгууламж бүрэн шинэчлэгдсэн. Насос станцын 6 кВ-ын тосон таслууруудыг вакуум таслуураар бүрэн сольж шинэчлэсэн. ТГ-2-оос бусад бүх үндсэн тоноглолын хяналт удирдлагыг DCS системд оруулсан.

ДМ-9.11.12.13, ДВ-9АБ,11Б, ПЭН-1.7-д давтамж хувиргагч суурилуулан ашиглаж байгаа. Системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор зарим давтамж хувиргагч тойруу тэжээлтэй ажиллаж байна

ӨДС-ын ТГ-8-ын хуучин РХ-ыг микропроцессорын РХ-аар шинэчлэхээр ажлын даалгаврыг боловсруулж байна.

ТГ-7-д тиристорын өдөөгч суурилуулахаар ирэх жилийн төлөвлөгөөнд оруулсан

Энэ онд ЭУН-ын нам сувгийн тавиуруудыг шинэчлэсэн. Ирэх онд ДДС-ын зуух, багер, ГРУ-6 кВ орчмын кабелийн сувагт ажил хийхээр төлөвлөсөн

Төслийн нэгжийн болон цахилгаан цехийн ИТА нартай бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Богино хугацаанд хийгдэх ажлын хүрээнд заасан “ОРУ-35, 110 кВ-н тосон

таслуурыг элегаз таслуураар шинэчлэх, изоляторууд, хуурай салгууруудыг тосон таслууруудтай нь хамт шинэчлэх” гэсэн хэрэгжүүлэх ажил, ТГ-5-ын 110 кВ-ын 9 ширхэг хуурай салгуур, ТГ-5.6-ын 110 кВ-ын цэнэг шавхагчийг ОПН болгон шинэчилж эхэлсэн.

Энэ ажлыг үргэлжлүүлэн ТГ-6-н 110 кВ-ын 12 ширхэг хуурай салгуур, ТГ-7.8-ын 110 кВ-ын цэнэг шавхагчийг ОПН болгох, 35 кВ-ын Сонгино-А.Б шугамын тосон таслуур хуурай салгуур, гүйдлийн трансформаторыг шинэчлэх ажлын даалгавар гаргаж, төсөв хийлгээд байна.

8.ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР



Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний биелэлт 96%-ийн гүйцэтгэлтэй, гарсан үр ашиг нь жилийн дүнгээр **129.2** мян.кВтц цахилгаан эрчим хүчийг хэмнээд байна. Алдагдлыг бууруулж түлш, уур ус, эрчим хүчний хэмнэлтийг гаргах ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, засварын зардлыг бууруулах талаар ажлуудыг зохион байгуулж хийснээр станцын хэмжээнд **325.3** сая төгрөгийн хэмнэлт гарсан байна Зарим ажлуудаас дурдвал:

- Туузан дамжлагын гэрлүүд нэгэн зэрэг асдаг байсныг өөрчилж ажиллагааны үед 1, 2, 3-р хэсэг бүрэн асах ба бусад үед эргэлт шалгалт хийх зэрэгт 2-р хэсэг дангаараа асдагаар өөрчилж шөнийн цагаар гэрэлтүүлэгт зарцуулах эрчим хүчийг хэмнэж байна.
- Гадна гэрэлтүүлэг, вагон хөмрөгчийн таазны гэрэлтүүлэгт цагийн реле суурилуулж ажиллах цагийг тохируулан хүний оролцоо бууруулж, хэмнэлттэй ухаалаг байдлаар ажиллах боломжийг бүрдүүлсэн.
- Цехүүдийн улайсах болон люминисцент гэрэлтүүлэгчийг 755 ширхэг LED гэрлээр сольж чадлын зөрүүгээр сард 20,165.0 кВтц буюу мөнгөн дүнгээр 2.2 сая төгрөг хэмнэж байна
- Дотоод хэрэгцээний дулаан хангамжийн цахилгаан эрчим хүчийг хэмнэх зорилгоор горим тохируулга хийх, шөнийн ачаалал бага цагаар бойлер таслах, насос зогсоох, инвертерийн ажиллагааг сайжруулах ажлуудыг хийж байна. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд 71,079.0 кВтц ДХЦЭХ-ийг хэмнэсэн байна.
- Горим ажиллагаанд уялдуулан зуухны туслах тоноглол бэлтгэлд зогсоож ДХЦЭХ хэмнэж төлөвлөгөөт хэмжээнд барих ажлуудыг үе үе хийж ажилласан. Тээрэм, тээрмийн салхилуур, мазутын насос богино хугацаанд зогсоох, мөн инвертерүүдтэй туслах тоноглолуудыг инвертерээр явуулах (одоогийн байдлаар 1 зуухны 2 тоноглол инвертерээр ажиллаж байна) зэрэг арга хэмжээнүүдийг авч ажилласан.

УХААЛАГ ЭРЧИМ ХҮЧ, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР



Эрчим хүчний ухаалаг үйлдвэрлэл, ухаалаг техник технологид шилжих зорилтын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөндөө 12 төрлийн ажил тусгасан. Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл 94%-тай ажлууд хийгдэж байна. Найман ажил бүрэн хийгдсэн ба бусад ажил графикайн дагуу хийгдэж байна.

Зарим ажлуудаас дурдвал:

- Давтамж хувиргагчууд системийн савлалтын үед зогсоод байгааг талаар судалгаа хийсэн. Зуух №9 болон СЭН 6, 8-ын давтамж хувиргагчуудад хүчдэлийн савалтын хамгаалалттай ба бусад нь хамгаалалтгүй суурилагдсан бөгөөд нэмэлтээр сайжруулах боломжгүй судалгаа гарсан.
- Зуух №12, 13-ын давтамж хувиргагчийн өрөөний нөхцөлийг сайжруулах, халсан агаарыг гадагш болон дотор нь хаядаг болгосон.
- Утааны хийн мониторингийн системийг ДДС-д тавих, ӨДС-ынхыг шинэчлэх талаар судалгаа хийсэн. ДДС-ын утааны хийн мониторингийн систем суурилуулах талаар судалгаа хийж үнийн судалгаа гаргасан. ӨДС-ын мониторинг шинэчлэх талаар судалгаа хийгдэж байна. Утааны хийн хорт бодисын хяналтыг 2020 оны 3-р сараас улсын нэгдсэн сүлжээнд холбосон.
- ТГ №5-9-д 110кВ, 12Тр-ийн 6кВ талд тоолуур нэмж А1805 маркийн 6 ширхэг ухаалаг тоолуурыг суурилуулж ЭХЗХ болон ДҮТ ХХК-ийн техникийн шаардлагыг хангасан.

9.ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР



Станцын хэмжээнд аваар, саатал гаргаагүй, үйлдвэрлэлийн осолгүй, галын ноцтой зөрчилгүй ажиллаж, хэмжих хэрэгслийн графикт баталгаажуулалтыг хугацаанд нь хийж, станцын дотоод циклийн химийн уур-усны горим, түлш, тосны чанарт хяналт тавьж зөрчилгүй ажиллалаа.

Сүүлийн 3 жилийн хугацаанд технологийн зөрчлийн тоо жил дараалан бууж байгаа бөгөөд 2020 онд нийт технологийн зөрчлийн тоо өмнөх оноос 5.8%-иар буурсан.

Технологийн зөрчил, гал түймэр, үйлдвэрлэлийн ослын харьцуулсан судалгаа

Д/д	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Аваар	-	-	-	-	-
2	Саатал-I	-	1	-	-	-
3	Саатал-II	1	1	-	-	-
4	Гэмтэл	63	45	41	35	33
5	Гал түймэр	-	-	-	-	-
6	Осол	1	-	-	3	-

2020 онд гарсан технологийн зөрчил болон үйлдвэрлэлийн ослын нэгдсэн дүн

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Аваари	тоо	-	-	-	-	-

	Үүнээс	Хүний буруугаар Техникийн шалтгаан						
2	Саатал-1		тоо	-	1	-	-	-
	Үүнээс	Хүний буруугаар Техникийн шалтгаан			1			
3	Саатал-2		тоо	1	1	-	-	-
	Үүнээс	Хүний буруугаар Техникийн шалтгаан		1	1			
4	Гэмтэл		тоо	63	45	41	35	33
	Үүнээс	Хүний буруугаар Техникийн шалтгаан Гадны байгууллага		9 49 5	5 35 5	6 31 4	3 28 1	1 26 6
5	Үйлдвэрлэлийн осол		тоо	1	-	-	3	-
	Үүнээс	Нас барсан Хүнд Хөнгөн					1 2	
6	Гал		тоо	-	2	2	2	1
	Үүнээс	Гал түймэр Галын зөрчил		- -	- 2	- 2	- 2	- 1
7	Ариун цэвэр		Дүн	3,96	3,97	3,95	3,93	3,92
8	Тоосжилт		Мг/м	16,8	17,7	17,5	21,0	19,1

2020 онд компанийн хэмжээнд аваар, нэг ба хоёрдугаар зэргийн саатал гараагүй, гэмтэл 27 удаа, гадны байгууллагаас хамаарсан гэмтэл 6 удаа, нийт судлан бүртгэгдсэн гэмтэл 33 удаа гарсан.

Цахилгаан хөдөлгүүрийн гэмтлийн хувьд 6кВ-ын цахилгаан хөдөлгүүрийн гэмтэл гараагүй, 0,4 кВ-ын цахилгаан хөдөлгүүрийн гэмтэл 6 удаа гарсан нь өмнөх оны хэмжээнд байна. 2020 онд гарсан цахилгаан хөдөлгүүрийн нийт гэмтлийг өмнөх онтой харьцуулахад гэмтлийн тоо өмнөх оноос 1-ээр буурсан байна.

➤ **Техник хяналтын талаар**

МХЕГ-ын бүртгэлтэй нийт 19 тоноглолд батлагдсан графикайн дагуу техникийн магадлал хийлгэх графиктай байснаас 16 тоноглолд техникийн магадлал хийлгэж, ашиглах зөвшөөрөл авсан ба 3 тоноглолын акт формуляр, протоколын бүрдүүлэлт хийгдсэн, Улсын байцаагчаар сунгалт хийлгэхээр хүлээгдэж байна.

Техникийн аюулгүй байдлыг хангуулах III шатны үзлэгийг “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн хүрээнд жилд 2 удаа хийж, үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг хугацаа, шийдвэрлэх хүрээнээс нь хамааруулан цех, хэсэгт үзлэгийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гарган зөрчлийг арилгуулж ажиллав.

Сар бүр аюулгүй ажиллагааны тодорхой зорилт тавьж, аюулгүй ажиллагааны тангараг, аюулгүй ажиллагааны 10 зарчмыг тогтмол мөрдөн ажиллаж байгаа нь чухал үр дүнгээ өгч, ажилчдын аюулгүй ажиллагаанд хандах хандлага эрс дээшилсэн.

Ажлын байрны эрсдлийн үнэлгээг жилийн туршид тасралтгүй хийж, аюулгүй ажиллагааны шат шатны зааварчилгаа, сургалтуудыг тогтмол явуулж ирсний үр дүнд аюулгүй ажиллагааны ноцтой зөрчил гаргаагүй ажиллалаа.

- 2020 оныг “Нарядын системийн мөрдөлтийг сайжруулж ажиллах жил” болгох зорилт дэвшүүлж, “нэг ажилд нэг наряд” бичих, нарядын системд ажлын аюулгүй байдлыг хариуцдаг субъектуудын үүрэг, хариуцлага болон осол, зөрчил гарахад шууд буруутай хүмүүст хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарлан таниулах, мөн наряд олгох талаар заавар, загвар боловсруулж, цех, хэсэг, нэгжүүдэд мөрдүүлж ажиллав. Мөн сар бүрийн аюулгүй ажиллагааны зорилтын төлөвлөгөөнд нарядын системийг чанд мөрдөж ажиллах талаар сэдэв оруулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар аюулгүй ажиллагаанд тавих хяналт дээшилсэн.
- “ХАБЭА-н сургалтын байр”-ны подвалын хэсэгт байрладаг зүүн, баруун талын өрөөг өөрсдийн хүчээр тохижуулан “ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ, ЭРСДЛИЙГ ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ ТАНХИМ”, “ГАМШГААС ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ ТАНХИМ”-ыг шинээр үүсгэн байгууллаа. Энэхүү танхимууд нь аюулгүй ажиллагаа болон галын аюулгүй байдал, гамшгийн сургалтуудыг тогтмол явуулах, гадны зочид болон дадлагын оюутнуудад үзүүлж байгууллагаа сурталчлах, ажилтнуудад ганцаарчилсан танхимын сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зан үйлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон гэж үздэг.
- Цехүүдийн дунд аюулгүй ажиллагааны зан үйл, соёлыг төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн орчин нөхцлийг сайжруулах, аюулгүй болон соёлч ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилчдыг аливаа эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор явуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэгч хамт олон” сэдэвт болзолт уралдаанд цехүүд маш идэвхтэй оролцсон ба ажлын байрны тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, аюулгүй ажиллагааны санамж плакатуудыг шинэчлэх, ХАБЭА-г сурталчлах самбар, үзүүлэнгүүдийг шинээр хийх, ажлын байрны эмх цэгц, эрүүл ахуйг сайжруулах, ажлын байрны аливаа аюулыг устгах талаар ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

➤ **Галын аюулгүй байдлыг хангуулах талаар:**

Гэрээт галын хэсэг болон станцын галын тоног төхөөрөмжийн засварын бригадтай хамтарч, галын тоноглолуудын бэлэн байдал, усан хангамж, хөөсөөр гал унтраах систем, утаа мэдээлэх систем, галын нарядын мөрдөлт, шатах тослох материал, түүний хадгалалт хамгаалалт, ашиглалт, ажлын байрны тоос тос, мазутын болон цахилгааны кабель сувгийн цэвэрлэгээ, гал унтраах багаж хэрэгслэлийн хангалт түүний ашиглалт, хадгалалт хамгаалалт, галын аюулаас сэрэмжлүүлэх санамж, тэмдэг, плакатуудын ашиглалт зэрэг нэн түрүүнд галын аюулгүй байдлыг хангах анхан шатны шаардлагатай 4 сэдвээр батлагдсан графикайн дагуу сар бүр хяналтын үзлэг хийж, гарсан зөрчлийг холбогдох цех, хэсгийн удирдлагуудад хугацаатай шаардлага өгч, зөрчлийг арилгуулж ажиллав.

2020 оны 06-р сарын 26-нд Гэрээт галын хэсэг, гал унтраах 14-р ангитай хамтран болзошгүй аюул ослын үед гарсан гал түймрийг унтраах, арга тактик, дадлага олгох, бэлтгэлийг дээшлүүлэх, гал унтраах хүч хэрэгслийг үнэлэх, харилцан хамтын ажиллагааг сайжруулах, байгууллагын ажилтан, албан хаагчдыг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилгоор Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн лабораторийн байранд тоног төхөөрөмжийн гэмтлийн улмаас гал түймэр гарч, галын шатлага эрчимтэй тархан дэлгэрэх аюултай нөхцөл байдал хүндэрсэн цагийн байдлаар гал түймэр унтраах тактикийн сургуулийг 3 үе шаттайгаар зохион байгуулж явууллаа.



Эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар:

МУ-ын хэмжээнд коронавируст халдварын цар тахлын бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11-р сарын 17-нд станцын харуулын төв шалган нэвтрүүлэх байранд биеийн халуун хэмжих автомат төхөөрөмж байрлуулж, компани руу нэвтэрч байгаа бүх ажиллагсдын халууныг хэмжиж байна. Ажлын байрны хаалга, шатны бариулуудыг 2 цаг тутамд халдваргүйжүүлэх уусмалаар арчиж байна. Цаг ашиглалтын хуруу унших төхөөрөмжийг ажилчдыг ажилд ирэхээс өмнө, ажил тарахаас өмнө зэрэг тогтсон цагуудад халдваргүйжүүлэх уусмалаар арчиж цэвэрлэж байна. Мөн гадна нэвтрэх үүдний хэсгийн талбай, орчныг халдваргүйжүүлэх бодисоор байнга шүршиж ариутгал хийж орох хаалганууд дээр гар ариутгах савтай ариутгалын уусмал байрлуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиулж байна .



Ажилтнуудад гар угаах нөхцлийг бүрдүүлж, шингэн саван, халдваргүйжүүлэх уусмалаар хангасан. Ажлын байр болон ахуйн байрнуудын гар ариутгалын савнуудыг ариутгалын уусмалаар байнга цэнэглэж, ээлжийн даргын өрөөнд амны маск, ам зайлах сода, нэг удаагийн резинэн бээлий, спиртэн суурьтай ариутгалын уусмал, жавелиний уусмал зэргийг тавьж, ажилчдад амны хаалтыг тогтмол хэрэглүүлж хэвшсэн.

Ажилчдыг олноор нь цуглуулахгүй, бөөгнөрөл үүсгэхгүй байлгах, хүн хоорондын 1,5-2м зай барьж ажиллах талаар заавар, зөвлөмжийг тогтмол өгч, хяналт тавин хэрэгжүүлж байна.



Халдвараас урьдчилан сэргийлэх тухай мэргэжлийн байгууллагуудаас өгсөн заавар, зөвлөмж, мөн станцын эмнэлгийн хэсгээс өгч байгаа эмчийн заавар зөвлөмжүүд, анхааруулах зурагт хуудсуудыг бүх ажлын байрууд, өрөө тасалгаанууд, цех хэсгүүдийн мэдээллийн самбар, ариун цэврийн өрөөнүүдэд байршуулан таниулж, сурталчилах ажлыг тасралтгүй хийж байна.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

Агаар бохирдуулах хорт бодисын хяналт

Станцын яндангаар хаягдаж байгаа хорт бодисын хэмжээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа MNS 5919:2008 стандартаас хэтрээгүй ажилласан.

Станцын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал

Тайлант хугацаанд 2137 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан нь өмнөх оноос 370 тн бага хог хаягдал гарсан байна. Станцын бүх ажлын байранд хог хаягдлаа ангилан ялгаж дахин боловсруулах гарын авлага, зөвлөмжийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

10.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

“ДЦС-3” ТӨХК нь 2020 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгөөр нийт 15,250,773.2 мянган төгрөгийн 185 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. 2020 онд ковид-19 цар тахалтай холбоотойгоор тухайн жил тэвчиж болох зардлуудаа танах чиглэлийн дагуу нийт 604,990 мянган төгрөгийн 26 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг цуцалсан. Дээрх 26 худалдан авалтыг хассан дүнгээр 14,645,783.2 мянган төгрөгийн 159 худалдан авалт зохион байгуулахаас бүгдийг нь зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. Худалдан авах ажиллагааны биелэлт 100 хувь байна.

Бид 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,632,576 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг дотоодоос худалдан авахаар гэрээ байгуулан ажилласан байна. Тэдгээрийг дурдвал:

- “Новатек интернэшнл” ХХК-тай тээрийн ган бөмбөлөг нийлүүлэх,
- “Жэй Эй Эйч” ХХК-тай хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх,
- “Координат эдвайс” ХХК-тай хөдөлмөр хамгааллын бээлий нийлүүлэх,
- “Билэг дизайн” ХХК-тай хөдөлмөр хамгааллын гутал нийлүүлэх,
- “Мэш” ХХК-тай давс нийлүүлэх,

- “АПУ дэйри” ХХК-тай нормын сүү нийлүүлэх,
- “Глобал ацетилен” ХХК-тай кислород нийлүүлэх,
- “Батзорлог” ХХК-тай Бутлагч М20*20 алх решетка хийх,
- “Нэмэх нэмэх” ХХК-тай эдийн саван нийлүүлэх,
- “Дээшлэх нар” ХХК-тай Төрөл бүрийн шүүр, арчих материал нийлүүлэх,
- “Мон полимер хоолой” ХХК-тай PVC болон бусад материалууд нийлүүлэх,
- “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай журнал, маягтууд нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаа. Гэрээний хэрэгжилтийн явцад аливаа нэгэн асуудал зөрчил үүсээгүй хугацаандаа хэрэгжсэн байна.

11. ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлэн “EQA IMS” ОУ-ын баталгаажуулалтын компанийн монгол дахь төлөөлөгч “MSCS” ХХК-ийн итгэмжлэгдсэн аудитаар шалгуулж 2020.08.14 нд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн байгууллага батламжаа гардан авсан нь компанийн хувьд онцлох үйл явдал байлаа. Энэхүү ажлын хүрээнд шинээр болон шинэчлэн сайжруулсан 248 баримт бичгийг боловсруулан ажилласан байна.

Чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөтэй байдал, тохиролд 3 шатны аудит хийгдсэний үр дүнд Сингапурт төвтэй ОУ-ын EQA IMS баталгаажуулалтын компаниас ISO 9001:2015 батламжийг гардан авч дэвшүүлсэн зорилтдоо хүрч ажиллаа. Гэрчилгээ авах ажлын хүрээнд 3 шатны аудитыг:

1. Дотоод аудитыг Компанийн чанарын аудитын багаар
2. Баримт бичгийн аудитыг “EQA IMS” ОУ-ын баталгаажуулалтын компанийн монгол дахь салбар “MSCS” ХХК-иар
3. Баталгаажуулалтын аудитыг “EQA IMS” ОУ-ын баталгаажуулалтын компанийн монгол дахь салбар “MSCS” ХХК-ийн итгэмжлэгдсэн аудитаар тус тус хийлгэж 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Олон улсын ISO 9001:2015 Чанарын гэрчилгээгээ гардан авсан.




Бүтээмж, чанар дээшлүүлэх хөтөлбөрийн үр дүнд компанийн гадаад дотоод давуу тал болон сул талыг тодорхойлж, эрсдлийн үнэлгээ хийн хариу арга хэмжээ төлөвлөх, нэгж хэсгүүдийн процессийн уялдаа холбоог сайжруулах, процессийн сайжруулалт хийх, эрсдлийг үнэлэх, баримт бичгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах, ажилтнуудын ажлын идэвх санаачлага, хандлага, багаар ажиллах чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр тохижилтыг сайжруулах, ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангахад тодорхой хувь нэмэр оруулаад байна.

Бүтээмж, чанар дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд “996 сайн санал, 996 сайн ажил, 996 эерэг үр дүн” сэдэвт жилийн аяныг 2 дахь удаагаа амжилттай хэрэгжүүлж нийт 1001 санал ирсэнээс 569 санал нь амжилттай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна. Компанийн хэмжээнд бүртгэлтэй 18 чанарын дугуйлангаас 8 чанарын дугуйлан тогтмол ажиллаж 13 төсөл, 36 ажлыг санаачлан хэрэгжүүлсэн байна.

12. НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД

Компанийн дотоод журам, 2019-2020 онд Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу компанийн ажилтан болон өндөр настан, ахмад, МШӨ-ний группийн хүмүүсээс ирсэн өргөдлийн дагуу буцалтгүй тусламж, хөнгөлөлт, нэмэгдэл, урамшууллыг олгож ажиллаж байна.



2020 онд ажилтнуудад тэтгэврийн тэтгэмж 27 хүнд 1081.7 сая төг, 22 хүнд буцалтгүй тусламж 64.9 сая.төг, орон сууцны дэмжлэгт нийт 43 ажилтан 137.7 сая төгрөг, шагнал урамжуулалд 130 ажилтанд 109.0 сая төгрөг, Өндөр настан, МШӨ группт гарсан Буцалтгүй тусламж, гарын бэлэгт 552 хүнд 164.7 сая төгрөг, тус тус олгуулж ажилласан.

Шагнал урамшууллын талаар

2020 онд нийт 108 ажилтныг төр засгийн одон медаль, МУ-ын Засгийн газрын шагнал, Монголын залуучуудын холбооны болон Монголын геологи, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрчний эвлэлийн холбооны шагналуудаар шагнуулж урамшуулах, шагнал урамшууллыг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.



Эрчим хүчний сайдын 2020 оны 287 дугаар тушаалаар байгуулсан “Салбарын шилдэг шалгаруулах комиссын шийдвэр”-ээр:

- Эрчим хүчний салбарын 2020 оны ШИЛДЭГ АЖИЛТАН-аар “Дулааны III цахилгаан станц” ТӨХК-ийн турбины машинч Баасанбат овогтой Бат-Өлзий шалгарсан нь манай байгууллагын хувьд томоохон амжилт боллоо.



Ажилчдын орон сууцны талаарх хийгдсэн ажил

Ажилчдын нийгмийн баталгааг хангах, тэдний өргөдөл гомдлыг барагдуулах, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хамтын гэрээг хэрэгжүүлэн ажиллаа. 2015 онд эхлүүлсэн “Эрчим” хотхоны төсөл гацаанаас гарлаа. Ажлыг эрчимжүүлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсэг нь эрчимтэй ажиллаж, компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс тодорхой шийдвэр гаргуулан 154 ажилтны нийгмийн асуудлыг шийдэх энэхүү томоохон ажил гацаанаас гарч 2021 оны 1-р улиралд ашиглалтанд орохоор болж байна. 10 залуу гэр бүл “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-т хамрагдлаа. Компанийн зүгээс НОСК, Улаанбаатар хотын захирагч, Монгол Улсын шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар нарт удаа дараа хандаж хөөцөлдсөны үр дүнд манай компанийн 10 залуу гэр бүл түрээсийн орон сууцанд хамрагдахаар боллоо.

13. ИЛ ТОД ЁС ЗҮЙН БАЙДАЛ

Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд МУ-ын засгийн газраас батлан гаргасан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу зохих мэдээллийг тогтмол оруулж явсан.

Үүнд:

- Тендерийн урилгууд
- ХАА-ны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө, тайлангууд
- Санхүүгийн тайлан, сар улирлын мэдээнүүд г.м

Компанийн үйл ажиллагааны мэдээллийг бүх ажилчдад ил тод, үнэн зөв, шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн цогц системийг тогтмол ажиллуулж байна. Үүнд:

- Дотоод сүлжээ
- Мэдээллийн самбар
- Компанийн цахим хуудас
- Компанийн facebook хуудас, group
- Телеграм

14. Компанийн 2020 оны онцлох үйл явдлаас дурдвал:

1. Үндсэн тоноглолын зогсолтыг 2 оронтой тоонд оруулсан
 - Тоноглолын найдвартай ажиллагааг ханган сүүлийн 10 жилийн дунджаар 136 байсан үндсэн тоноглолын зогсолтыг тоог 99 болгон 2 оронтой тоонд орууллаа.
2. Түүхэндээ хамгийн өндөр дулааны эрчим хүчийг түгээсэн
 - 2020 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 2369.4 мян.Гкал дулааны эрчим хүчийг түгээсэн.
3. Шинээр үнсэн сан барих ажил хийгдэж дууссан.
 - Шинэ үнс хадгалах сангийн технологи нь газрыг ухахгүйгээр нягтруулсан шороон далан босгож ус, хий үл нэвтрүүлэх олон улсад ашиглагддаг геомембран доторлогоог хоёр давхарлуулж, үнс хадгалах сангийн ойролцоо газрын доорх усны бохирдлыг хянах бүрэн автомат хяналтын гурван цооног тавьж сүлжээнд холбогдсон.
4. Техникийн бодлогын баримт бичгээ шинэчилсэн.
 - Цехүүд их засвар, хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэлийн талаар баримтлах 2025 он хүртэлхи техникийн бодлогын баримт бичгийг шинэчилсэн
5. ISO 9001:2015 Чанарын удирдлагын стандартын батламж гардан авсан.
 - 2020 онд компанийн хэмжээнд ЧУТ-ны ISO 9001:2015 стандартыг амжилттай хэрэгжүүлэн “EQAIMS” ОУ-ын баталгаажуулалтын компанийн монгол дахь төлөөлөгч “MSCS” ХХК-ийн итгэмжлэгдсэн аудитаар шалгуулж 2020.08.14-нд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн байгууллага батламжаа гардан авлаа.
6. 10 ажилтаныг Түрээсийн орон сууц хөтөлбөрт хамруулсан
 - Компанийн зүгээс холбогдох байгууллагуудад хандаж манай компанийн 10 залуу гэр бүл түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдсан. Энэ хөтөлбөр нь урьдчилгаа төлбөргүй орон сууцаа түрээслээд өмчлөх боломж олгодог. Энэ нь эрчим хүчний салбараас анх удаа хамрагдаж байгаа тохиолдол юм.

15. 2020 ОНЫ АЖЛЫГ ТОВЧ ДҮГНЭВЭЛ:

- Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн болон түгээлтийн төлөвлөгөөг 101.8%-иар, дулааны ачаалал жил бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үед дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 102.0%-иар, диспетчерийн графикийг 104%-иар биелүүлж үндсэн үүргээ биелүүлж ажиллалаа.
- Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг төлөвлөгөөт хэмжээнд барьж, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 3.94 гр/кВтц, дулаанд 0.04 кг/Гкал- аар тус тус нэмэгдсэн.
- Нийт орлогын төлөвлөгөөг 100.6 хувиар давуулан биелүүлж, нийт зардлын төлөвлөгөөг 102.9 хувиар хэтрүүлэн ажилласан. Энэ нь ТӨБЗГ-ын шийдвэрээр үндсэн тоноглолуудад дахин үнэлгээ хийгдсэнээр элэгдлийн хэмжээ өссөн, диспетчерийн горимын дагуу ЦЭХ, ДЭХ-ийн түгээлт 12 сард нэмэгдсэнтэй холбоотой түлшний зардлын нэмэгдэл гол нөлөө үзүүлсэн. 2020 онд ашиг алдагдалгүй байхаар төлөвлөж гүйцэтгэлээр зардлын өсөлтийн нөлөөгөөр 2.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан ба өмнөх оноос 615 сая төгрөгөөр бууруулж ажилласан.
- Оны эхнээс үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасах болсонтой холбоотойгоор татварын авлага 831.2 сая төгрөгөөр, Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс Засгийн газрын 211 тогтоолын дагуу ААН, иргэдийн цахилгаан, дулаан, уурын төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотойгоор уурын болон өөрийн шинийн борлуулалтын орлого Засгийн Газраас төлөгдөөгүйгээс 427.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад авлагыг 107.4 сая төгрөгөөр бууруулсан. Нийт өглөгийн хэмжээг оны эхнээс 3.6 тэрбум төгрөгөөр бууруулж, нүүрсний өр төлбөрийг барагдуулж ажилласан.
- 2020-2021 оны өвлийн бэлтгэл ажлыг хангаж 4 үндсэн тоноглолд их засвар, 3 үндсэн тоноглолд дунд засвар, 107 туслах тоноглолд их засвар хийж гүйцэтгэлээ. Үндсэн тоноглолын их засваруудад зуух №6,9,10-ийн их засвар, зуух №3,4-ийн нэмэлт халах гадаргуу, Турбингенератор №4, №5-ын их засварын ажлуудыг хийж өвлийн бэлтгэл хангаж ажилласан.
- Хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил, Техник зохион байгуулалтаар хийгдэх 6 ажлыг бүрэн хийж дуусгалаа.
- 2020 онд компанийн техникийн бодлогын хүрээнд хийгдсэн томоохон ажлуудын нэг болох шинэ үнсэн сан барих төслийн ажлыг бүрэн хийж дуусгасан бөгөөд техникийн комисс ажиллаж ажиллагаанд орулаад байна.
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулсан. Аваар болон 1 ба 2-р зэргийн саатал гаргаагүй ажилласан. Хүний амь үрэгдсэн болон бүлэг осол гаргаагүй ажилласан.
- 2020 оныг Эрчим хүчний салбарын хэмжээнд “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих жил”-болгон зарласан ба бид энэхүү ажлын хүрээнд үндсэн 3-н чиглэлд 33 ажил төлөвлөж 90.9% гүйцэтгэлтэйгээр амжилттай хэрэгжүүлсэн:
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлэн “EQAIMS” ОУ-ын баталгаажуулалтын компанийн монгол дахь төлөөлөгч “MSCS” ХХК-ийн итгэмжлэгдсэн аудитаар шалгуулж 2020.08.14 нд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн байгууллага хэмээх батламжийг гардан авлаа.
- Монгол улсын хэмжээнд коронавируст халдварын цар тахал дэгдэж бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахиж ,

халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж ажилласнаар нийт ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалж улмаар үйлдвэрийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаа .

2021 ОНЫ ЗОРИЛТ

1. 2021 онд эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн, өр авлагыг барагдуулж, зардал бууруулах
2. Техник эдийн засгийн үзүүлэлийг өмнөх оны түвшингээс бууруулахгүй байх
3. Үйлдэрлэлийн осолгүй, аваар болон нэгдүгээр зэргийн саатал гаргахгүй, галын зөрчилгүй ажиллах
4. Үндсэн тоноглолын их засварыг графикт хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж өвлийн их ачаалалд оролцуулах, их засвараас шалтгаалсан үндсэн тоноглолын зогсолт гаргалгүй өмнөх оны амжилтаа бататгаж ажиллах
5. 2021 оныг "Тоног төхөөрөмжийн цоож, пайзны системийг чанд мөрдөж ажиллах жил" болгон зорилт тавин, хэрэгжүүлж ажиллах
6. Бараа материал, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтын ажлыг хуулийн хүрээнд, цаг хугацаанд нь зохион байгуулж ажиллах
7. Компанийн хэмжээнд сургалтын үйл ажиллагааг цахимжуулах, цахим сургалтын үйл ажиллагааг дэмжиж сургалтын оролцоо, хэрэглээг сайжруулан хүний нөөцийн чадавхийг сайжруулж ажиллах зорилтуудыг тавьж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЧИНБАТ